



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/63

Мандалговь

Хөрөнгийн үнэлгээний ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хоршооны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.9, Хүнс хөдөө аж ахуйн сайдын 2021 оны А/361 дугаар тушаалын хавсралтын 3.4.4, мөн сайдын 2022 оны А/243 дугаар тушаалын хавсралтын 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хоршоог хөгжүүлэх сан”-ийн зээлд барьцаалах үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг тогтоох чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга : Сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: Санхүү албаны дарга

Дотоод ажилтан Засаг даргын туслах

Нарлаг багийн Засаг дарга

Тэвш багийн Засаг дарга

2. Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж захиалагчийн хүсэлтийн дагуу холбогдох материалыг үндэслэн орон нутгийн зах зээлийн ханштай уялдуулан үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг бодитой тогтоож зээлдэгч тус бүрээр тайланг ирүүлэхийг ажлын хэсгийн дарга (Ц.Лхагвасүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ





ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/44

Мандалговь

“Хоршоог хөгжүүлэх сан”-аас
зээл олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.5, 59 дүгээр зүйлийн 59.1.7, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дугаар тушаалын хавсралтын 6 дугаар зүйлийн 6.6, 6.7, 8 дугаар зүйлийн 8.3, мөн сайдын 2022 оны А/243 дугаар тушаалын хавсралтын 3 дугаар зүйлийн 3.25 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хоршоог хөгжүүлэх сан”-ийн Төсөл сонгон шалгаруулах хорооны хуралдаанаар дэмжигдсэн орон нутгийн нөөцөд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлж хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх 1 хуулийн этгээд, 8 иргэний зээлд шаардагдах 458,000,000.00 (дөрвөн зуун тавин найман сая) төгрөгийн төслийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Хөнгөлөлттэй зээлийг зориулалтын дагуу ашиглан баталсан хуваарийн дагуу төлж, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээний тайланг улирал бүр тайлагнаж, ажлын байрыг шинээр нэмэгдүүлж, тогтвортой хадгалж, эрүүл, аюулгүй үйлдвэрлэл, үйлчилгээгээр хангаж ажиллахыг нийт зээлдэгч иргэн, хуулийн этгээдүүдэд үүрэг болгосугай.

2. Зээл олгогдсон иргэн, хуулийн этгээдүүдэд зээлийн зориулалт ажлын байр, үйл ажиллагаа, эргэн төлөлтөд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг “Хоршоо хөгжүүлэх сан”-ийн нарийн бичгийн дарга (Ш.Бямба), ня-бо (Ц.Ууганбаяр) нарт хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ

4873010110



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 37

Мандалговь

Хоршоог хөгжүүлэх сангийн 2023 оны
төсөл сонгон шалгаруулах тов зарлах тухай


Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн 35.1.17 дахь заалт, Хоршооны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийн 41.1.9 дэх заалт, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дугаар тушаалын хавсралтын 2.10, 2.11 дэх заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Хоршоог хөгжүүлэх сан”-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг 2023 оны 1 дүгээр сарын 9-ны өдрөөс эхлэн 2 дүгээр сарын 9-ны өдрийг дуустал хугацаанд цаасаар хүлээн авах товыг зарласугай.

2. Товлогдсон хугацааг хоршоо, Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд болон олон нийтийн цахим, мэдээллийн хэрэгслээр мэдээлж ажиллахыг Жижиг дунд үйлдвэр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн, “Хоршоог хөгжүүлэх сан”-ийн нарийн бичгийн дарга /Ш.Бямба/-д үүрэг болгосугай.

3. “Хоршоог хөгжүүлэх сан”-аас 2023 онд олгох зээлийн төсөлд, батлагдсан тэргүүлэх чиглэлийг баримтлан ажиллахыг төсөл сонгон шалгаруулах хорооны дарга Тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Т.БАТЖАРГАЛ



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 36

Мандалговь

Хоршоог хөгжүүлэх сангийн 2023 оны
төслийн салбар, чиглэл батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн 35.1.17 дахь заалт, Хоршооны тухай хуулийн 42 зүйлийн 42.1 дэх хэсгийн 42.1.9 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А-361 дугаар тушаалын хавсралтын 2.10, 2.11 дэх заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. "Хоршоог хөгжүүлэх сан"-аас 2023 онд олгох зээлийн төсөлд баримтлах салбар, чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Хоршоо, Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх бодлого, дэвшүүлсэн зорилт, хөтөлбөр, төлөвлөгөөнүүдтэй уялдуулан орон нутгийн давуу тал, нөөцөд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн төслийг сонгон шалгаруулахад анхаарч ажиллахыг төсөл сонгон шалгаруулах хорооны дарга /Ц.Лхагвасүрэн/-д үүрэг болгосугай.

3. Батлагдсан салбар, чиглэлийг баримтлан зээлийг олгож, сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, эргэн төлөлтөд, хяналт тавьж үр дүнг тайлагнаж ажиллахыг орон тооны бус хяналтын зөвлөлийн дарга /Б.Батбаяр/-д даалгасугай.

ДАРГА  Т.БАТЖАРГАЛ

